



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 1008

Хараат

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6, 49 дүгээр зүйлийн 49.2.10 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ний 86 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 3 дугаар зүйлийн 3.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар “Мөнхөлзий алт мөнгөн гадас” ХХК-ны гүйцэтгэсэн “Ахмадын байрны засвар, үйлчилгээ” -ний ажлыг хүлээн авах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: - Ш.Мөнх-Оргил (ЗДТГ-ын дарга)

Нарийн бичиг: -З.Ням (Санхүү албаны дарга)

Гишүүд: -Б.Мөнхтогтох (ХАА-н мэргэжилтэн)

-Ж.Чулуунтогтох (Ерөнхий нягтлан)

-М.Доржсүрэн (ЗДТГ-ын нярав)

2. Гүйцэтгэлийн чанар үр дүнд үнэлэлт дүгнэлт өгч хүлээн авсан акт үйлдэж баталгаажуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ш.Мөнх-Оргил)-д үүрэг болгосугай.

3. Ажил хүлээлцсэн акт холбогдох бичиг баримтыг үндэслэн ЗДТГ-ын өмчид бүртгэхийг нягтлан бодогч (Ж.Чулуунтогтох) -д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  А.ЭРДЭНЭСАЙХАН



4822000148